

ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2019.02.11-02.15

ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛ

АНУ: Өнгөрсөн 7 хоногт АНУ, БНХАУ хоорондын хэлэлцээр “Маш үр дүнтэй” болсон гэж хоёр талын эрх баригчид мэдээлж, АНУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд 8 долоо хоног дараалан өсөлттэй хаагдлаа. S&P 500 индексийн сагсанд багтдаг эрчим хүч болон аж үйлдвэрийн салбарын компаниудын хувьцааны ханш өссөн бол санхүүгийн болоод ус, дулаан, цахилгаан хангамжийн компаниудын хувьцааны ханш буурсан үзүүлэлттэй байна.

ОПЕК-ийн улс орнууд болоод ОХУ газрын тосны гарцаа танах шийдвэр гаргаснаар газрын тосны ханш 5 орчим хувиар өсөж, эрчим хүчний компаниудын хувьцааны ханшид эергээр нөлөөлөв.

АНУ-ын Худалдааны яамны мэдээлснээр өнгөрсөн оны 12-р сард жижиглэнгийн худалдаа 2009 оноос хойшхи хамгийн их хэмжээгээр буюу 1.2%-аар буурчээ.

АНУ-ын 10 жилийн хугацаатай Засгийн газрын үнэт цаасны өгөөж бага хэмжээний өсөлттэй байв. 2019 оны 1-р сард АНУ-ын инфляцийн түвшин өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.6%-аар өссөн бол 2018 оны 12-р сартай харьцуулахад 0.1%-аар буурчээ.

Европ: АНУ, БНХАУ хоорондын худалдааны маргааны асуудалд ахиц гарч байгаатай холбогдуулан Европын хөрөнгийн зах зээлийн индексүүд өсөлттэй хаагдлаа. Европын бүсийн эдийн засгийн удаашрал болоод “Brexit” хэлэлцээрийн тодорхойгүй байдал хөрөнгийн зах зээлд төдийлөн нөлөө үзүүлээгүй ажээ.

Германы эдийн засаг саарч байгаа мэдээлэл гарч, Еврогийн ханш ам.долларын эсрэг бага зэрэг сулрав. 2018 оны 12-р сард Герман улсын аж үйлдвэрийн гарц 0.4 хувиар буурсан бол тус улсын эдийн засаг өсөлт үзүүлээгүй байна.

Их Британийн Парламент тус улсын Ерөнхий сайд хатагтай Тереза Мэйн өргөн барьсан “Brexit” хэлэлцээрийн төслийг батлахгүй байхаар шийдвэрлэв. Ингэснээр фунтийн ханш ам.долларын эсрэг сулрав.

Япон: Японы хөрөнгийн зах зээлийн Nikkei 225 индекс 2.8%-аар өслөө.

Япон улсын эдийн засаг 2018 оны IV улиралд бага хэмжээгээр эргэн сэргэлээ. IV улиралд тус улсын эдийн засаг 1.4 хувиар өсжээ. 2018 оны III улиралд тохиосон байгалийн гамшгийн дараа дотоодын эрэлт нэмэгдсэн нь ийнхүү эдийн засгийн өсөлтийг дэмжсэн байна.

IV улиралд Японы эдийн засаг ахин сэргэсэн хэдий ч БНХАУ-ын эдийн засгийн өсөлт буурч, тарифын маргаантай холбоотой эрсдэлүүд байгаа аж. Түүнчлэн тус улсын Засгийн газар эдийн засгийн өсөлтийг зорилтот түвшинд хадгалах зорилгоор 2019 оны аравдугаар сараас эхлэн борлуулалтын татвараа нэмэхээр төлөвлөж байна.

БНХАУ: АНУ, БНХАУ хоорондын худалдааны маргааны асуудалд ахиц гарснаар БНХАУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд өсөлттэй хаагдлаа.

Эх сурвалж: Reuters, Troweprice

Олон улсын индексүүд

Индекс	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	21,579.42	-0.55% ▼
Dow Jones	АНУ	25,883.25	3.09% ▲
S&P 500	АНУ	2,775.60	2.50% ▲
Nasdaq	АНУ	7,472.41	2.39% ▲
S&P/TSX	Канад	15,838.24	1.31% ▲
FTSE 100	Их Британи	7,236.68	2.34% ▲
S&P/ASX 200	Австрали	6,066.10	-0.09% ▼
Nikkei 225	Япон	20,900.63	2.79% ▲
Hang Seng	Хонг Конг	27,900.84	-0.16% ▼

Бондын өгөөж

Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.750%	110.77
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.625%	99.03
Mongol 2022 (Чингис)	USD	5.125%	98.64
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.875%	111.33
DBM' 23 (Самурай)	JPY	1.520%	104.63
DBM' 2023	USD	7.250%	102.00
TDBM' 2020	USD	9.375%	104.46

Зах зээлийн хүү

Хүү	Хаалт	Өөрчлөлт
Libor 1M	2.480	-0.02 ▼
Libor 3M	2.680	-0.02 ▼
Libor 6M	2.750	0.01 ▲
Libor 1YR	2.900	-0.04 ▼
US 2YR Bond	2.514	0.00 ▲
US 3YR Bond	2.489	0.00 ▲
US 5YR Bond	2.493	0.00 ▲
US 10YR Bond	2.663	0.00 ▲

Валютын ханш /төг/

Валют	2019.02.15	Өөрчлөлт
USD	2,632.71	0.07% ▲
CNY	388.36	-0.44% ▼
EUR	2,969.43	-1.36% ▼
RUB	39.48	-1.62% ▼
KRW	2.33	-0.85% ▼
JPY	23.86	-0.38% ▼
CAD	1,977.85	-1.54% ▼

Түүхий эдийн үнэ

Түүхий эд	Хэмжих нэгж	Хаалт	Өөрчлөлт
Алт /спот/	USD/t oz.	1,324.53	0.78% ▲
Мөнгө /спот/	USD/t oz.	15.79	-0.22% ▼
Зэс	USD/lb.	283.00	0.69% ▲
Нүүрс	USD/MT	91.80	-1.92% ▼
WTI газрын тос	USD/bbl.	55.75	5.75% ▲
Brent газрын тос	USD/bbl.	66.07	6.39% ▲
Байгалийн хий	USD/MMBtu	2.64	2.33% ▲

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2019. I	7.30%
Бодлогын хүү	2019. I	11.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2018. XII	10.80%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2018. XII	12.00%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2018. XII	5.30%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2018. XII	17.10%
Зээлийн дундаж хүү /валют/	2018. XII	10.50%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА


Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн биржийн хоёрдогч зах зээлийн энгийн арилжаагаар 35 компанийн 663.1 сая төгрөгийн 1,530,271 ширхэг хувьцаа арилжигдав.

“Орхон хөгжил” /HJL/ компанийн хувьцаа 15.00%-аар буюу хамгийн ихээр өсч 328.8 төгрөгт хүрч хаагдсан бол “Адуун чулуун” /ADL/ компанийн хувьцаа 23.81%-аар буурч 1,600.0 төгрөгт хүрч хаагдлаа.

Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч болон хоёрдогч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.


2-р сарын 15-ны өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,513.3 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 21,579.42 нэгж болж өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 0.55%-аар буурсан байна.

MSE Индекс



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Арилжааны үнийн дүн /7 хоногоор, 2019 он/



*2018 оны 12-р сарын 31-ний өдрийн арилжааг хасан тооцсон

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Зах зээлийн хураангуй

Хураангуй	Үнийн дүн /сая төг/
Арилжигдсан үнийн дүн	663.1
Зах зээлийн үнэлгээ	2,513,345.5

Зах зээлийн индекс

Индекс	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	21,579.42	-0.55% ▼
MSE I индекс	10,072.75	2.67% ▲
MSE II индекс	8,504.31	0.43% ▲

Идэвхтэй арилжигдсан хувьцаа

Компани	Ширхэг	Үнийн дүн /төг/
Говь	691,501	230,388,447
АПУ	277,033	168,935,405
Таван толгой	12,199	89,197,290
Мандал даатгал	8,339	43,724,240
Ард даатгал	59,564	41,694,940

Өсөлттэй хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Орхон хөгжил	328.80	15.00% ▲
Таван толгой	7,510.00	13.70% ▲
Жуулчин дютти фрий	124,900.00	13.55% ▲
Баянтээг	20,000.00	9.41% ▲
Улсын их дэлгүүр	497.27	8.57% ▲

Бууралттай хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Адуун чулуун	1,600.00	-23.81% ▼
Хөх ган	60.01	-11.75% ▼
Монгол шуудан	558.18	-6.97% ▼
Монгол шевро	2,430.00	-5.81% ▼
Монгол базальт	256.38	-4.69% ▼

Арилжаанд идэвхтэй оролцсон үнэт цаасны компаниуд

Компани	Арилжааны үнийн дүн /төг/
Би Ди Сек	558,863,956
Голомт Капитал	214,143,601
Ти Ди Би Капитал	150,452,549
Бумбат-Алтай	109,927,992
Новел Инвестмент	61,214,525

Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани

Компани	Хаалт /төг/	ЗЗҮ /сая.төг/
АПУ	618.00	657,664
Таван толгой	7,510.00	395,516
МИК	14,750.00	305,462
Говь	334.76	261,150
Сүү	210.00	72,240

ЗГҮЦ БОЛОН КОМПАНИЙН БОНДЫН АРИЛЖАА

ЗГҮЦ-ны анхдагч зах зээл

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
-	-	-	-	-	-	-	-

ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээл

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
-	-	-	-	-	-	-	-

НОГДОЛ АШИГ ЗАРЛАСАН ХУВЬЦААТ КОМПАНИУД

№	Симбол	Компанийн нэр	Нэгж хувьцааны ногдол ашиг /төг/	Нийт ногдол ашиг /сая төг/	Шийдвэр огноо	Бүртгэлийн өдөр	Хуваарилах өдөр
1	MBW	Монгол базальт ХК	1.0	56.4	2019.02.01	N/A	2019.10.01-с
2	BTG	Баянтээг ХК	3,958.7	1,000.0	2019.02.11	2019.03.04	2019.06.01-с
3	GOV	Говь ХК	6.8	5,304.8	2019.02.13	N/A	2019.04.25-с
4	ADU	Хөвсгөл алтан дуулга ХК	120.0	1,888.1	2019.02.13	N/A	2019.05.01-с

ЭЭЛЖИТ ХУРАЛ ЗАРЛАСАН ХУВЬЦААТ КОМПАНИУД

№	Симбол	Компанийн нэр	Бүртгэлийн өдөр	Хуралдах өдөр	Хуралдах цаг
1	IBA	Их барилга ХК	2019.01.27	2019.02.20	11:00
2	HRM	Гермес центр ХК	2019.02.18	2019.03.07	15:00
3	SVR	Эрдэнэт суврага ХК	2019.02.08	2019.03.11	11:00
4	BLG	Завхан баялаг ХК	2019.02.27	2019.03.18	10:00
5	LEND	ЛэндМН ББСБ ХК	2019.02.22	2019.03.23	12:00
6	BTG	Баянтээг ХК	2019.03.04	2019.04.01	10:00
7	MIB	Монинжбар ХК	2019.02.05	2019.04.05	14:30
8	HRD	Хүрд ХК	2019.03.04	2019.04.05	16:00
9	VIK	Баян-Алдэр ХК	2019.03.04	2019.04.08	10:00
10	HUZ	Хөвсгөл усан зам ХК	2019.02.28	2019.04.08	09:00

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

“Түмэн шувуут” ХК-ийн үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа 2019.02.18-нд эхэлнэ

Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 2 дугаар сарын 11-ний өдрийн 1/407 тоот албан бичгийн дагуу олон нийтэд шинээр үнэт цаасаа санал болгон арилжаалсан “Түмэн шувуут” ХК-ийн анхдагч зах зээлийн арилжааг амжилттай болсонд тооцож, тус компанийн үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааг 2019 оны 2 дугаар сарын 18-ны өдрөөс эхлүүлэхээр боллоо.

Тус компани нь нийт хувьцааныхаа 25 хувийг олон нийтэд санал болгож 10 тэрбум төгрөгийг олон нийтээс татан төвлөрүүлсэн бөгөөд хувьцааны анхдагч зах зээлийн арилжааны захиалга олон нийтэд санал болгосон дүнгээс 9.1 хувиар давж ирсэн юм.

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж



“Эрдэнэ ресурс девелопмент корпорэйшн” нь хаалттай хүрээнд нэмэлт хувьцаа гаргана

“Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн” (TSX: ERD | MSE: ERDN) нь Монгол улсын баруун өмнөд хэсэгт орших өөрийн 100% эзэмшлийн Хөндий алтны төслийн анхан шатны эдийн засгийн тооцооллыг Канад улсын цахим тайлан мэдээний SEDAR системд нийтэлсэн байна.

Тус анхан шатны эдийн засгийн тооцооллоор 8 жилийн хугацаанд жилд дунджаар 3.42 г/т дундаж алтны агуулга бүхий 51,200 унц алт олборлох, өдөрт 1,800 тонн хүдрийг баяжуулан боловсруулахаар тус тус төлөвлөсөн бөгөөд дараах голлох үзүүлэлтүүдийг гаргасан байна. Үүнд:

- Алтны үнийг \$1,200/унц-аар төсөөлөн тооцоход татварын дараах өнөөгийн цэвэр үнэ цэнэ (5% хоргодуулалтаар) \$99 сая ам.доллар, өгөөжийн дотоод хувь (“IRR”) нь 56%;
- Алтны үнийг \$1,300/унц-аар төсөөлөн тооцоход татварын дараах өнөөгийн цэвэр үнэ цэнэ (5% хоргодуулалтаар) \$124 сая ам.доллар, өгөөжийн дотоод хувь (“IRR”) нь 68%;
- Төслийн анхан шатны хөрөнгө оруулалт 32 сая ам.доллар;
- Нэг унц алт үйлдвэрлэх зардал (“AISC”) нь \$714 ам.доллар;
- Хөрөнгө оруулалтаа нөхөх хугацаа: 2 жил.

Мөн “Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн” нь Торонтогийн хөрөнгийн биржид 7,608,696 ширхэг үнэт цаасыг нэмэлтээр бүртгүүлж, нэг бүрийг нь 0.23 кан.доллараар хаалттай хүрээнд санал болгон худалдаж, нийт 1,750,000 кан.долларын хөрөнгө оруулалтыг татахаар төлөвлөж байгаа тухай мэдэгдлээ.

Тус компани нь татан төвлөрүүлсэн хөрөнгийг Хөндий Алтны Төслийн Урьдчилсан Техник Эдийн Засгийн Үндэслэлийг боловсруулах, ашиглалтын тусгай зөвшөөрлийн өргөдөл гаргах, Монгол Улсын Уул Уурхай, Хүнд Үйлдвэрийн Яамнаас олгож эхэлсэн тусгай зөвшөөрлийн сонгон шалгаруулалтад оролцох, компанийн эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэх зэрэг үйл ажиллагаанд зарцуулахаар төлөвлөж байна.

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

“Ард кредит ББСБ” ХК-ийн үнэт цаасны захиалга хүлээн авах мэдээлэл

Монголын хөрөнгийн биржид шинээр бүртгэгдсэн “Ард Кредит ББСБ” ХК-ийн олон нийтэд санал болгон арилжаалахаар төлөвлөж байгаа үнэт цаасны танилцуулга арга хэмжээг хөрөнгийн зах зээлийн мэргэжлийн оролцогч нарт зориулан 2 дугаар сарын 14-ний өдөр Ард санхүүгийн нэгдлийн байранд хийсэн билээ.

“Ард кредит ББСБ” ХК нь 2011 онд үүсгэн байгуулагдсан, “Ард санхүүгийн нэгдэл” ХК-ийн хөрөнгө оруулалттай компани бөгөөд зээл олгох, цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулга зэрэг үйлчилгээг эрхэлдэг. Тус компани нь зээлийн бүтээгдэхүүнийг санхүүжүүлэх зорилгоор нийт хувьцааныхаа 25 хувь буюу 70,000,000 ширхэг хувьцааг нэг бүрийг нь 70 төгрөг ба түүнээс доошгүй (70-85 төгрөг) төгрөгөөр олон нийтэд санал болгон худалдаалж, нийт 4.9 тэрбум төгрөг ба түүнээс доошгүй хэмжээний хөрөнгийг төгрөгийг татан төвлөрүүлэхээр ажиллаж байна.

“Ард кредит ББСБ” ХК-ийн андеррайтераар “Ард Капитал ҮЦК” ХХК ажиллаж байгаа бөгөөд үнэт цаасны худалдан авах захиалгыг 2019 оны 2 дугаар сарын 18-наас 2019 оны 3 дугаар сарын 01-ний өдрийн хооронд Монголын хөрөнгийн биржийн бүх гишүүн үнэт цаасны компаниудаар дамжуулан хүлээн авах юм.

Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

ХК-ууд ногдол ашиг олгохтой холбоотой шийдвэрээ 2-р сарын 19-ний дотор гаргана

Санхүүгийн зохицуулах хорооноос Компанийн тухай хуулийн дагуу “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ыг мөрдүүлдэг. Хуульд хувьцаат компани (ХК)-ууд Хувьцаа эзэмшигчдийн хурал (ХЭХ)-аа санхүүгийн жил дууссанаас хойш дөрвөн сарын дотор буюу дөрөвдүгээр сарын 30-наас өмнө зарлан хуралдуулахаар заасан. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ) ХЭХ-ыг хуралдуулах тухай шийдвэрээ уг хурал болох өдрөөс 40-өөс доошгүй хоногийн өмнө гаргах бөгөөд шийдвэрийг гурав хоногийн дотор Санхүүгийн зохицуулах хороонд мэдэгдлээр ирүүлнэ. Шийдвэр гарснаас хойш хурлын товд өөрчлөлт оруулахыг хуулиар хориглодог.

Дээр дурдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-аар хурал хуралдуулахтай холбоотой үйл ажиллагааг цаг хугацаатай нь нарийвчлан журамласан. Тухайлбал, энэ сарын 19-ны дотор хувьцаат компаниудын ТУЗ ногдол ашиг олгохтой холбоотой шийдвэрээ гаргаж баталгаажуулах учиртай. Улмаар ирэх сарын 21-ний дотор ХЭХ-ыг хуралдуулах тухай шийдвэрээ гаргаж, 24-ны дотор Хороонд мэдэгдэнэ. Ингээд гуравдугаар сарын 26-ны дотор ХЭХ-ын зарыг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр хувьцаа эзэмшигчдэд зарлаж, 31-ний дотор үнэт цаасны компани (ҮЦК)-уудад хүргэдэг. ХЭХ хуралдуулах тухай энэхүү зарыг дөрөвдүгээр сарын 10-ны дотор дахин олон нийтийн мэдээллийн хэрэгслээр мэдээлэх бөгөөд ингэхдээ анхны мэдээлсэн хэлбэр, агуулгыг өөрчлөхгүй.

ХЭХ-ын зарыг нийтэд мэдээлснээс 15-20 дахь хоногт буюу дөрөвдүгээр сарын 15-ны дотор хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдийг бүртгэж нэрсийн жагсаалт гаргах бөгөөд бүртгэлийн өдрийг ТУЗ хурлын шийдвэрийг гаргахдаа тогтоосон байна. Ингээд Компанийн тухай хуульд заасан хугацаанд буюу дөрөвдүгээр сарын 30-ны дотор хуралдуулж, хурлын шийдвэрийг хурал хуралдсанаас хойш 3 хоногийн дотор Хороонд ирүүлнэ.

ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

ҮСХ: Нүүрсний экспорт сарын дүнгээр 11.7%-иар буурав

Монгол Улсын гадаад худалдааны нийт барааны эргэлт энэ оны нэгдүгээр сарын байдлаар 1.1 тэрбум ам.долларт хүрч өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад 41.6%-аар өссөн байна. Энэ дундаа нийт экспорт 607.3 сая ам.доллар /43.3%-ийн өсөлттэй/, импорт 504 сая ам.доллартай /39.6%-ийн өсөлттэй/ тэнцжээ. Гадаад худалдааны нийт тэнцэл өнгөрсөн сард 103.3 сая ам.долларын ашигтай гарсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 64.7%-аар өссөн дүн юм. Түүнчлэн, 2018 оны дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт 6.9%-тай гарсан тухай Үндэсний статистикийн хороо (ҮСХ) мэдээллээ. Ийнхүү өсөхөд үйлчилгээ, аж үйлдвэр, барилгын салбарын өсөлт голлон нөлөөлсөн байна.

Нэгдүгээр сард эрдсийн экспорт 425.7 сая ам.долларт хүрч өмнөх оны мөн үеийнхээс 21%-аар өсжээ. Орлогоор тэргүүлэгч салбар болох нүүрсний экспорт 170.8 сая ам.долларт хүрч 23.7%-аар нэмэгдсэн байна. Нүүрсний экспортын биет хэмжээ өнгөрсөн сард 2.16 сая тонн хүрсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 8.4%-аар давсан. Гэсэн хэдий ч өнгөрсөн арванхоёрдугаар сарын дүнгээс 12 орчим хувиар буурсан үзүүлэлт боллоо.

Зэсийн баяжмалын экспортын тухайд мөн хугацаанд 117.4 мянган тонн бүтээгдэхүүн нийлүүлж 157.3 орчим сая ам.долларын орлого олсон нь биет хэмжээгээр 20.5%-аар, үнийн дүнгээр 24%-аар тус тус нэмэгдсэн байна. Боловсруулсан цэвэр зэсийн хувьд мөн хугацаанд 760 тонн бүтээгдэхүүн экспортолж, 4.4 орчим сая ам.долларын орлого олсон нь жингээр 34.6%-аар, орлогын тухайд 44.8%-аар тус тус буурчээ.

Түүхий газрын тосны тухайд манай улс өнгөрсөн сард нийтдээ 534 мянга орчим баррелийн экспорт хийсэн бөгөөд 27 сая ам.долларын орлого олсон байна. Энэ нь биет хэмжээгээр 3.9%-аар, үнийн дүнгээр 21.7%-аар тус тус буурчээ.

Боловсруулаагүй буюу хагас боловсруулсан алтны экспорт өнгөрсөн сард 3.1 тоннд хүрч, орлогын дүнгээр 130 сая ам.доллартай тэнцсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 5 дахин нэмэгдсэн дүнтэй байна. Гэхдээ Монголбанкны мэдээлж буйгаар алт худалдан авалт өнгөрсөн сард 597 кг хүрсэн нь 47%-аар буурсан үзүүлэлт болж байгаа юм.

Төмрийн хүдрийн экспортын хувьд өнгөрсөн сард нийтдээ 608.6 мянган тонн бүтээгдэхүүн гадагш нийлүүлж, 26 сая ам.доллар олсон нь биет хэмжээгээр 39.4%, орлогын дүнгээр 47.9%-аар тус тус өссөнийг илтгэв.

Цайрын хүдэр, баяжмалын экспорт өнгөрсөн сард 12 мянган тоннд хүрч, 17.1 сая ам.долларын орлого олсон байна. Энэ нь жингээр 7.8%, орлогын дүнгээр 11.9%-аар тус тус өссөн байна.

Жоншны хүдэр, баяжмалын экспорт эхний нэг сарын байдлаар 53.6 мянган тоннд хүрсэн нь өмнөх оныхоосоо 84.3%-аар нэмэгдсэн бол орлогын хувьд 17.7 сая ам.доллар олж 91.7%-ийн өсөлтийг харуулав.

Хар тугалганы хүдэр, баяжмалын экспорт нэгдүгээр сард 1.6 мянган тоннд хүрч 3.7 орчим сая ам.долларын орлого олсон нь жингээр 2.6 дахин, үнийн дүнгээр 2.3 дахин тус тус өсөв.

Молибденийн баяжмалын экспорт биет хэмжээгээр 0.5 мянган тонн, орлогын дүн 4.2 сая ам.доллартай тэнцжээ. Энэ нь жингээр 4.8%-аар, үнийн дүнгээр 48.1%-аар тус тус нэмэгдсэн гэсэн үг.

Гянтболдын хүдэр, баяжмалын экспорт өнгөрсөн сард 20 тоннд хүрч, 219.3 сая ам.долларын орлого олсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад жингээр 23.1%-аар, үнийн дүнгээр 37.9%-аар тус тус буурчээ.

Эх сурвалж: MongolianMiningJournal.com

БНХАУ-ын нүүрсний бодлого Монголд боломж олгоно гэж "Aspire Mining" үзэж байна

"БНХАУ-ын нүүрсний импортоо хязгаарлах бодлого Монголын нүүрс экспортлогчдод боломж болно" гэж үзэж байгаагаа "Aspire Mining" компанийн тэргүүн Дэвид Полл онцолж байна.

"IHS Markit"-ийн тооцоолсноор 2018 онд БНХАУ-ын нүүрсний импортын 44 хувийг Австрали, 43 хувийг Монгол Улс нийлүүлжээ. Гэхдээ ойрын жилүүдэд энэ байр солигдож, Монгол Улс нүүрсний нийлүүлэлтээрээ тэргүүлнэ гэж таамаглаж байна. "Aspire Mining"-ийн хувьд жорк стандартаар тогтоосон 281.1 сая тонн нүүрсний нөөц бүхий Овоот коксжих нүүрсний төслийн эхний шатны урьдчилсан ТЭЗҮ-ийг энэ сард боловсруулж дуусах юм.

Монгол болон Торонтогийн Хөрөнгийн биржид давхар бүртгэлтэй "Erdene Resource Development" компани "Хөндий" алтны төслийн бие даасан урьдчилсан эдийн засгийн тооцооллоо Канадын цахим тайлан мэдээний "sedar" системд нийтэлсэн байна. Нэг унц алтыг 1,200 ам.доллараар тооцвол төслийн өгөөж 56 хувь байхаар тооцож байгаа аж. Анхны хөрөнгө оруулалт 32 сая ам.доллар гэж үзэж байна. "Хөндий" төсөлд багтаж байгаа "Баян хөндий" ордын олборлолтын лиценз авах хүсэлтээ гаргажээ. I улиралд багтаан шийдвэр гарна гэж харж байгаа бол хоёр дахь орд болох "Алтан нар" төсөлд олборлолтын лицензээ авах хүсэлтээ II улиралд багтаан гаргахаар төлөвлөсөн байна.

Үүнээс гадна Торонтогийн Хөрөнгийн биржид бүртгэлтэй "Kinco Copper" компани нэг бүрийг нь 0.12 канад доллароор үнэлж, 787,500 ширхэг хувьцаа хаалттай хүрээнд гаргахаар бэлтгэж байна. Тус компанийн хувьцааны ханш сүүлийн арилжаагаар 4.5 хувиар өсөж, 0.12 канад доллар боллоо. "Kinco Copper" компани Зүүн Цагаан суварга, Хүрэл үнэг талбайд геофизикийн судалгаа хийж дууссан юм. Цаашид өрөмдлөг хийж болохуйц сайн дүн гарсан гэж мэдээлээд байна. Мөн I улиралд дахин өрөмдлөг хийхээр төлөвлөж байгаа ажээ.

Эх сурвалж: BloombergTv.mn

I сард Шивээхүрэнгийн нүүрсний экспорт Гашуунсухайтынхаас давлаа

Нэгдүгээр сард Шивээхүрэн-Сэхэ боомтын нүүрсний экспорт хамгийн том боомт болох Гашуунсухайт-Ганцмодныхоос давж гарсан байна. Шивээхүрэн-Сэхэ боомтоор нэгдүгээр сард 978.8 мянган тонн нүүрс экспортолжээ.

Нарийнсухайтын бүлэг ордос олборлолт хийж буй компаниуд экспорт хийж байгаа бөгөөд энэ дунд "Southgobi Sands" хамгийн их хэмжээний буюу 403.9 мянган тонн нүүрс экспортолсон байна. Үүний дараа "Монголын алт", "Өсөх зоос" компаниуд экспортын үзүүлэлтээрээ удаалжээ.

Гашуунсухайт-Ганцмод боомтоор нэгдүгээр сард 918 мянган тонн нүүрс экспортолсон байна. Мөн нийт 8,046 автомашин нүүрс тээвэрлэн гаргасан нь 2018 оны мөн үеэс 40 хувиар өссөн үзүүлэлт гэж "Гашуунсухайт авто зам" ХХК мэдээллээ. Гашуунсухайт-Ганцмод боомтоор Тавантолгойн бүлэг ордод олборлолт хийж буй гурван компани нүүрс экспортолж байна. Ялангуяа "Эрдэнэс Таван толгой" ХК-ийн экспорт хамгийн их буюу 484 мянган тонн байсан бол орон нутгийн өмчит "Тавантолгой" ХК-ийнх 157.9 мянган тонн болсон байна.

Нэгдүгээр сард гол хоёр боомт болох Гашуунсухайт, Шивээхүрэнгээр нийт 1.89 сая тонн нүүрс экспортлоод байна.

Эх сурвалж: BloombergTv.mn

БУСАД МЭДЭЭ

ҮСХ: Монгол улсын эдийн засгийн 2018 оны 12-р сарын байдал

Дотоодын нийт бүтээгдэхүүн

ДНБ, 2010 оны зэрэгцүүлэх үнээр 2018 оны урьдчилсан гүйцэтгэлээр 18.1 их наяд төгрөг болж, өмнөх оноос 1.2 (6.9%) их наяд төгрөгөөр өслөө. Уг өсөлтөд үйлчилгээний салбарын нэмэгдэл өртөг 383.4 (5.3%) тэрбум төгрөг (санхүү, даатгалын үйл ажиллагааны салбарын нэмэгдэл өртөг 139.0 (12.3%) тэрбум төгрөг), аж үйлдвэр, барилгын салбарын нэмэгдэл өртөг 357.1 (6.2%) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлөв.

ДНБ, оны үнээр 2018 оны урьдчилсан гүйцэтгэлээр 32.2 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 4.3 (15.3%) их наяд төгрөгөөр өслөө.

Улирлын нөлөөллийг арилган тооцсоноор ДНБ, 2010 оны зэрэгцүүлэх үнээр 2018 оны 4 дүгээр улиралд өмнөх улирлаас 2.5 хувиар өслөө.

Эцсийн ашиглалтын аргаар тооцсон ДНБ, оны үнээр 2018 оны урьдчилсан гүйцэтгэлээр 31.5 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 3.8 (13.5%) их наяд төгрөгөөр өслөө.

Мөнгө, зээл

Мөнгөний нийлүүлэлт (М2) 2019 оны 1 дүгээр сарын эцэст 19.7 их наяд төгрөг болж, өмнөх сараас 182.6 (0.9%) тэрбум төгрөг, өмнөх оны мөн үеэс 3.9 (24.7%) их наяд төгрөгөөр өссөн байна.

Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө 2019 оны 1 дүгээр сарын эцэст 1.0 их наяд төгрөг болж, өмнөх сараас 70.6 (7.3%) тэрбум төгрөг, өмнөх оны мөн үеэс 237.3 (29.6%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2019 оны 1 дүгээр сарын эцэст 17.2 их наяд төгрөг болж, өмнөх сараас 6.2 (0.04%) тэрбум төгрөгөөр буурч, өмнөх оны мөн үеэс 3.6 (26.1%) их наяд төгрөгөөр өссөн байна.

Төгрөгийн америк доллартай харьцах Монголбанкны нэрлэсэн дундаж ханш 2019 оны 1 дүгээр сард 2,649.68 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 9.2 хувиар, өмнөх сараас 0.5 хувиар тус тус суларсан байна.

Төгрөгийн юаньтай харьцах Монголбанкны нэрлэсэн дундаж ханш 2019 оны 1 дүгээр сард 390.38 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 3.4 хувиар, өмнөх сараас 1.9 хувиар тус тус суларчээ.

Улсын нэгдсэн төсөв

Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, тусламжийн нийт хэмжээ 2019 оны 1 дүгээр сарын урьдчилсан гүйцэтгэлээр 690.6 тэрбум төгрөг, зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 558.2 тэрбум төгрөг болж тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 132.3 тэрбум төгрөгийн ашигтай гарлаа.

Төсвийн тэнцвэржүүлсэн орлого 160.2 (30.2%) тэрбум төгрөг, нийт зарлага, цэвэр зээлийн хэмжээ 142.0 (34.1%) тэрбум төгрөгөөр өмнөх оны мөн үеэс тус тус өслөө.

Улсын нэгдсэн төсвийн орлогын 73.8 хувийг татварын орлого, 7.6 хувийг татварын бус орлого, 18.6 хувийг ирээдүйн өв сангийн орлого эзэлж байна.

Төлбөрийн тэнцэл

Төлбөрийн тэнцлийн урсгал ба хөрөнгийн дансны тэнцэл 2018 оны урьдчилсан гүйцэтгэлээр 1.8 тэрбум америк долларын алдагдалтай гарч, өмнөх оноос 694.2 сая америк доллараар өсжээ.

Урсгал данс 1.9 тэрбум америк долларын алдагдалтай гарахад үйлчилгээний тэнцэл 1.4 тэрбум америк доллар, анхдагч орлогын данс 1.4 тэрбум америк долларын алдагдалтай гарсан нь голлон нөлөөлсөн байна.

Хөрөнгийн данс 2018 онд 86.6 сая америк долларын ашигтай гарч, өмнөх оноос 9.0 (11.6%) сая америк доллараар өссөн байна. Харин санхүүгийн дансны тэнцэл 1.7 тэрбум америк долларын ашигтай гарч, өмнөх оноос 928.4 (35.7%) сая америк доллараар буурчээ. Төлбөрийн тэнцэл 2018 онд 141.2 сая америк долларын алдагдалтай гарч, өмнөх оноос 1.6 тэрбум америк доллараар өссөн байна.

Гадаад худалдаа

Монгол Улс 2019 оны 1 дүгээр сард нийт 105 улстай худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 1.1 тэрбум америк доллар, үүнээс экспорт 607.3 сая америк доллар, импорт 504.0 сая америк долларт хүрлээ.

Нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 326.3 (41.6%) сая америк доллар, үүнээс экспорт 183.4 (43.3%) сая америк доллараар, импорт 142.8 (39.6%) сая америк доллараар тус тус өссөн байна.

Гадаад худалдааны тэнцэл 2018 оны 1 дүгээр сард 62.7 сая америк долларын ашигтай гарч байсан бол 2019 оны 1 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 40.6 (64.7%) сая америк доллараар өсөж 103.3 сая америк доллар болжээ.

Үнэ

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2019 оны 1 дүгээр сард улсын хэмжээнд өмнөх сараас 0.6 хувиар өсөж, өмнөх оны мөн үеэс 7.3 хувиар өссөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2019 оны 1 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 7.3 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 10.8 хувь (согтууруулах бус ундааны дэд бүлгийн үнэ 5.7 хувь, сүү, сүүн бүтээгдэхүүн, өндөгний дэд бүлгийн үнэ 9.7 хувь), согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 4.1 хувь, тээврийн бүлгийн үнэ дүнгээрээ 5.9 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 10.5 хувь (цахилгаан, хийн болон бусад түлшний дэд бүлгийн үнэ 13.1 хувь), эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 10.5 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2019 оны 1 дүгээр сард өмнөх сараас 0.6 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 3.4 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 0.8 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ 0.7 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК нь мэдээллийн үнэн бодит байдал баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК хариуцлага хүлээхгүй болно.